



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/50

Жаргалтхаан сум

Газар ашиглуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутагт MV-022571 дугаартай уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигч “Найртын дэнж” ХХК (6085571)-д Жаргалтхаан сумын 4 дүгээр багийн нутагт “Од” нэртэй, 4375698 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай, уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалттай, 5370972 квадрат метр газрыг 5 жилийн хугацаагаар ашиглуулсугай.

2.Холбогдох хууль тогтоомжид заасны хүрээнд газар ашиглах эрхээ хэрэгжүүлж, ашиглалтын газраа хуулийн дагуу кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлж, газрын төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлж барагдуулахыг газар ашиглагчид үүрэг болгосугай.

3.Газар ашиглагчид газар ашиглах эрхийн гэрчилгээ олгож, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэх, газрын ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Н.Ууганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ

Data (D:) /A4 zahiramj

232501133